

**10 дугаар бүлэгт дурдсан
10 дугаар хавсралт**

Албадан хураалт

1. 10.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг нь дараахь хоёр нөхцөлийг хамаарч байгаа талаарх нэгдсэн ойлголтоо Талууд үүгээр нотолж байна:

- (a) нэгдүгээр нөхцөл нь шууд албадан хураах бөгөөд хөрөнгө оруулалтыг улсын өмч болгох, эсхүл албан ёсны өмчлөлийн эрхийг шилжүүлэх, эсхүл шууд битүүмжлэх замаар албадан хураах;
- (b) хоёрдугаар нөхцөл нь шууд бус албадан хураах бөгөөд энэ нь аль нэг Талын авсан арга хэмжээ, эсхүл хэд хэдэн арга хэмжээ нь эрхийг шилжүүлэх, эсхүл шууд битүүмжлэлгүйгээр шууд албадан хураахтай адил нөлөөлөлтэй байх.

2. Нэг Талын авсан аливаа арга хэмжээ, эсхүл цогц арга хэмжээ нь тодорхой тохиолдлын нөхцөлд, шууд бус албадан хураалт мөн эсэхийг тодорхойлохдоо тухайн тохиолдол бүрт баримтад суурилсан судалгаа болон дараахь гол хүчин зүйлийг харгалзана:

- (a) арга хэмжээний эдийн засгийн нөлөөлөл (хэдийгээр нэг Талын авсан аливаа арга хэмжээ, эсхүл цогц арга хэмжээний байдал нь хөрөнгө оруулалтын эдийн засгийн үнэ цэнэд сөрөг нөлөөлсөн ч дангаараа, шууд бус албадан хураалт бий болсон гэж тогтоохгүй);
- (b) тухайн арга хэмжээ нь тодорхой, үндэслэлтэй мөн хөрөнгө оруулалтаас үүссэн хүлээлтэд саад учруулсан хэмжээ;
- (c) тухайн арга хэмжээ тэр дундаа зорилгын шинж чанар.

3. Аливаа авсан арга хэмжээ, эсхүл цогц арга хэмжээ нь, зорилтынхоо хүрээнд хэт чанга болсноос сайн санааны үндсэн дээр баталсан, эсхүл хэрэгжүүлсэнийг нь үндэслэлтэйгээр нотлох боломжгүй тохиолдолдлоос бусад тохиолдолд аль нэг Талын үл ялгаварлах арга хэмжээ, хууль ёсны нийтийн эрх, ашгийн төлөө зорилгыг хамгаалахын тулд зориулсан бол энэ нь шууд бус албадан хураалт гэж үзэхгүй.